



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.27 № 01/05 ҮАГ-САГ/2013/11/ЦТА-ТЧУЗ

Төсвийн орлого болгох тухай

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны аппаратын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны шинэ барилгын доорх 30 автомашины зогсоолыг бусдад түрээслүүлсний орлогын 30.0 сая төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23.3-д “гатварын бус орлого нь ...төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлогоос бүрдэнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1-т “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улсын төсөвт төвлөрүүлээгүй 30.0 сая төгрөгийг 2013 оны 12 дугаар сарын 20-ны дотор Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Дээрх төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргал, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
 Үндэсний аудитын газрын
 аудитор 
 Д.Гандолгор
 УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:
 ҮХААЯ-ны ТНБД-ын үүргийг
 түр орлон гүйцэтгэгч 
 Х.Золжаргал
 Ерөнхий нягтлан бодогч

 Б.Ариунжаргал

070017